

ТӨСӨЛ

ҮХГ-ын даргын 2020 оны ... дугаар сарын
... өдрийн ... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛЭЭР ХЭРЭГЖИХ ТӨСЛИЙН ЗАРДАЛ,
АШГИЙН ТООЦОО ХИЙХ, ТУХАЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ**

2020 он

АГУУЛГА:

1. Нийтлэг үндэслэл
2. Төслийн анхны хөрөнгө оруулалтын зардал
3. Төслийн бэлтгэл ажиллагааны зардал
4. Үйл ажиллагааны орлого, зардлын тооцоо
5. Төслийн цэвэр ашиг, мөнгөн урсгалын тооцоо хийх
6. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төслийг үнэлэх
7. Төслийн хорогдуулсан хувийг тооцох арга
8. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих боловсрол, эрүүл мэндийн салбарын төслийн зардал, үр өгөөжийн шинжилгээ хийх
9. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн санал ирүүлэхдээ бөглөж ирүүлэх маягтууд. Үүнд:
 - 1) Маягт 1. Төслийн үндсэн мэдээлэл
 - 2) Маягт 2. Төслийн нийгмийн ач холбогдол
 - 3) Маягт 3. Төслийн эдийн засгийн үр ашиг
 - 4) Маягт 4. Төслийн санхүүжилтийн төлөвлөгөө
 - 5) Маягт 5. Төсөл хэрэгжүүлэх Хууль, эрх зүйн орчны болон Улс, бүс нутаг, орон нутаг, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх судалгаа
 - 6) Маягт 6. Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан байдал
 - 7) Маягт 7. Төслийн дэд бүтцийн хэрэгцээ
 - 8) Маягт 8. Ажлын байр

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төслийн зардал, ашгийн тооцоо хийх, тухайн төслийг үнэлэх аргачлал

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төслийн зардал, ашгийн тооцоо хийх, тухайн төслийг үнэлэх аргачлалын зорилго нь төслийн анхны хөрөнгө оруулалтын зардал, төслийн үргэлжлэх хугацааны орлого, зардал, ашиг, мөнгөн урсгалыг бодитой таамаглах, анхны хөрөнгө оруулалтаа нөхөж, үр ашигтай ажиллах эсэхийг тодорхойлоход оршино.
- 1.2 Энэхүү аргачлалыг Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн үндэслэлийг гаргах, зардал, ашгийн тооцоо хийх, шалгах, төслийг үнэлэхэд дагаж мөрдөнө.
- 1.3 Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих боловсрол, эрүүл мэндийн салбарын төслийн зардал, үр өгөөжийн шинжилгээ хийх, нийгэм, эдийн засгийн өгөөжийн үндсэн үзүүлэлтийг тооцохдоо энэхүү аргачлалын хоёрдугаар хавсралтыг ашиглана.
- 1.4 Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн санал ирүүлэхдээ энэхүү аргачлалын гуравдугаар хавсралтын үндсэн мэдээлэл, төслийн танилцуулга, суурь судалгааны маягтуудыг бөглөж ирүүлнэ.
- 1.5 Төслийн орлого, зардал, ашгийн тооцоонд дараах зүйлсийг зайлшгүй харгалзах шаардлагатай. Үүнд:
 - 1.5.1 *Зах зээлийн багтаамж*: Төслийн хүчин чадал, орлогыг таамаглахдаа тухайн төслийн хэрэгжих зах зээлийн багтаамжийг харгалзан үзнэ.
 - 1.5.2 *Түүхэн мэдээлэл*: Төслийн орлого, зардлын тооцоог хийхэд хэрэгжүүлэх гэж буй төсөлтэй ижил төсөвтэй төсөл, бизнес, үйл ажиллагаануудын гүйцэтгэлийн мэдээллийг судалж, ирээдүйн таамаглалыг үндэслэл бүхий үнэн зөв, бодитой тоон мэдээлэл, тооцоо судалгаанд суурилан хийнэ.
 - 1.5.3 *Валютын ханш*: Төсөл нь валютын ханшнаас ихээхэн хамааралтай хэрэгжихээр бол валютын ханшийг өнгөрсөн үеийн мэдээлэл дээр үндэслэн статистик, математик аргуудын тусламжтайгаар таамаглана.
 - 1.5.4 *Гадаад орчны нөлөө*: Төсөлд улс төр, эдийн засаг, нийгэм, технологийн үзүүлэх нөлөөг төсөв боловсруулахад харгалзана.
 - 1.5.5 *Салбарын нөлөө*: Төсөлд нийлүүлэгч, хэрэглэгч, өрсөлдөгч зэргийг харгалзан үзнэ.

Хоёр. Төслийн анхны хөрөнгө оруулалтын зардал

- 2.1 *Анхны хөрөнгө оруулалт* гэдэг нь тухайн хөрөнгийг барьж бий болгох, шинэчлэн сайжруулах зэрэг төслийн бүтээн байгуулалтын үе шат хүртэлх буюу төслийн үйл ажиллагааг эхлэх хүртэл гарах хөрөнгө, зардлыг ойлгоно. Дараах төрлийн хөрөнгө, зардлууд багтана.
 - 2.1.1 *Газрын төлбөр*: төсөлд газар худалдан авах, газрын нөхөн төлбөр төлөх зэрэг зардлууд гарч болно

- 2.1.2 *Барилга, байгууламж, газрын сайжруулалт*: төслийн хугацаанд баригдах барилга, байгууламж, газрын сайжруулалтыг төсөвт өртгийн дагуу таамаглана.
- 2.1.3 *Машин, тоног төхөөрөмж*: худалдан авах үнэ дээр суурилуулж ашиглахад бэлэн болох хүртэл зардлыг нэмсэн дүнгээр тооцно.
- 2.1.4 *Тээврийн хэрэгсэл*: худалдан авах үнэ дээр суурилуулж ашиглахад бэлэн болох хүртэл зардлыг нэмсэн дүнгээр тооцно.
- 2.1.5 *Тавилга, эд хогшил*: худалдан авах үнэ дээр суурилуулж ашиглахад бэлэн болох хүртэл зардлыг нэмсэн дүнгээр тооцно.
- 2.1.6 *Компьютер, бусад хэрэгсэл*: худалдан авах үнэ дээр суурилуулж ашиглахад бэлэн болох хүртэл зардлыг нэмсэн дүнгээр тооцно.
- 2.1.7 *Анхны хөрөнгө оруулалтын бусад зардал*
- 2.1.8 *Хүүгийн капиталжуулалт*: Үндсэн хөрөнгийг бий болгохтой холбогдон гарсан зээлийн хүүгийн зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт оруулан тооцож болно.
- 2.1.9 *Биет бус хөрөнгө оруулалт*: Төслийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай тусгай зөвшөөрөл, зохиогчийн эрх, програм хангамж, патент зэргийг хэлнэ.
- 2.2 *Бэлтгэл ажиллагааны зардал*: Төсөл эхлүүлэхтэй холбоотой техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, суурь судалгаа хийх, боловсон хүчин бэлтгэх, бүтээн байгуулалтын үед гарах зардлууд орно. Үүнд:
 - 2.2.1 *Бүтээн байгуулалтын үеийн даатгалын зардал*: Бүтээн байгуулалт хийх явцад эрсдэлээс сэргийлэх зорилгоор даатгал хийлгэж болох бөгөөд энэхүү даатгалын зардлыг төсөвлөнө.
 - 2.2.2 *Хууль, эрх зүйн зардал*: Төслийг эхлүүлэхтэй холбоотой эрх зүйн туслалцаа авах, бичиг баримт бүрдүүлэхтэй холбоотой эрх зүйн төлбөр гарах тохиолдолд энэхүү хэсэгт төсөвлөнө.
 - 2.2.3 *Бэлтгэл ажиллагааны бусад зардал*: Төслийг эхлүүлэхтэй холбогдон гарах үйл ажиллагааны зардлыг энэ хэсэгт төсөвлөнө.

Гурав. Үйл ажиллагааны орлого, зардлын тооцоо хийх

- 3.1 Төслийн хувьд ирээдүйд олох орлогыг хүчин чадал, зах зээлийн ирээдүйн төлөв байдлаас хамааруулан он тус бүрээр таамаглана. Орлогыг дараах төрлийн хувьд төсөвлөнө. Үүнд:
 - 3.1.1 *Бараа борлуулалтын орлого*: Төслийн үндсэн үйл ажиллагаагаар бараа, бүтээгдэхүүн борлуулснаас олох орлого.
 - 3.1.2 *Үйлчилгээ үзүүлсний орлого*: Төслийн үндсэн үйл ажиллагаагаар үйлчилгээ үзүүлснээс олох орлого.
 - 3.1.3 *Бусад мөнгөн орлого*: Бараа, бүтээгдэхүүн борлуулах болон үйлчилгээ үзүүлэх үндсэн орлогоос гадна төслийн явцад үйл ажиллагаанаас олох бусад орлого.
 - 3.1.4 *Төслийн нийт орлого*: Дээрх гурван төрлийн орлогын нийлбэр. Төслийн цэвэр орлогын нэгтгэлийг дараах хэлбэрээр гаргаж болно.

№	Орлогын төрөл		... он	... он	... он	... он	... он
1	Бараа борлуулалтын орлого	+					
2	Үйлчилгээ үзүүлсний орлого	+					
3	Бусад мөнгөн орлого	+					
	Нийт орлого	=					

Санамж: Ирээдүйд олох орлогыг тооцохдоо тухайн жил тус бүрээр ажил, үйлчилгээ үзүүлэх хүчин чадлын тоо хэмжээ болон үнэ, тарифыг үнэн зөв, бодитой тоон мэдээлэлд үндэслэн тодорхой тусгасан байх шаардлагатай.

3.2 Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд (элэгдлийн зардал ороогүй дүн) төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төслийн бүтээн байгуулалтын үе шат дууссаны дараах буюу ашиглалтад орж, үйл ажиллагаа эхэлснээс хойш гарах Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 3-р бүлэгт заасан зардлууд орно.

3.3 Татварын зардал: Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварыг хуульд заасан хувь хэмжээгээр тооцно.

3.4 Элэгдлийн зардал: Барилга, байгууламж, бусад үндсэн хөрөнгийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13-р зүйлд заасны дагуу дор дурдсан хугацаагаар ашиглахаар тооцож, түүний элэгдэл, хорогдлын шимтгэлийг шулуун шугамын аргаар тооцно.

№	Үндсэн хөрөнгийн бүлэг	Ашиглах хугацаа /жилээр/
1	Барилга, байгууламж	40
2	Машин, механизм, техник, тоног төхөөрөмж	10
3	Компьютер, түүний эд анги, программ хангамж	3
4	Ашиглах хугацаа нь тодорхойгүй биет бус хөрөнгө	10
5	Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө /Үүнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна./	Хүчин төгөлдөр байх хугацаанд
6	Бусад үндсэн хөрөнгө	10
7	Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үйлдвэрлэл, технологийн парк доторх барилга, байгууламж	20
8	Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үйлдвэрлэл, технологийн парк доторх үйлдвэрлэлийн зориулалттай машин, механизм, техник, тоног төхөөрөмж	3

Санамж: Холбогдох хууль, журамд өөрчлөлт орсон тохиолдолд түүнийг дагаж мөрдөнө.

3.5 Төслийн зардлын тооцооны нэгтгэлийг дараах хэлбэрээр гаргаж болно.

Төслийн онцлогоос хамааран зардлын төрөл, ангилал өөрчлөгдөж болно.

№	Зардлын төрөл	... он	... он	... он	... он	... он
1	Үндсэн үйл ажиллагааны зардал:					
1.1	Ажиллагчдын цалингийн зардал					
1.2	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал					
1.3	Томилолтын зардал					
1.4	Бичиг хэргийн зардал					
1.5	Шуудан холбооны зардал					
1.6	Мэргэжлийн үйлчилгээний зардал					
1.7	Сургалтын зардал					
1.8	Сонин сэтгүүл захиалгын зардал					
1.9	Даатгалын зардал					
1.10	Ашиглалтын зардал					
1.11	Засварын зардал					
1.12	Түрээсийн зардал					
1.13	Харуул хамгааллын зардал					
1.14	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал					
1.15	Тээврийн зардал					
1.16	Шатахууны зардал					
1.17	Хүүгийн зардал					
1.18	Зар сурталчилгааны зардал					
Үндсэн үйл ажиллагааны нийт зардал						
Нийт зардал						

Дөрөв. Төслийн цэвэр ашиг, мөнгөн урсгалын тооцоо хийх

4.1 Төслийн нийт орлогын дүнгээс үндсэн үйл ажиллагааны зардал, элэгдлийн зардал, үйл ажиллагааны бус зардал, татварын зардлыг хасаж төслийн жил тутмын цэвэр ашгийг тодорхойлно.

№	Үзүүлэлт/ нөлөөлөл		Концессын хугацаа /жилээр/				Дүн
			1	2	n	
1	Нийт орлого	+					
2	Борлуулалтын өртөг	-					
2	Үндсэн үйл ажиллагааны зардал	-					
3	Элэгдлийн зардал	-					
4	Үйл ажиллагааны ашиг	=					
5	Үйл ажиллагааны бус зардал	-					
6	Татварын өмнөх ашиг	=					
7	Орлогын албан татварын зардал	-					
8	Цэвэр ашиг	=					

4.2 Төсөл үргэлжлэх жил тутмын мөнгөн урсгалыг дараах төрлүүдээр тодорхойлно.

Үүнд:

- Үйл ажиллагааны мөнгөн урсгал
- Санхүүжилтийн мөнгөн урсгал
- Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал
- Цэвэр мөнгөн урсгал

4.2.1 Үйл ажиллагааны мөнгөн урсгал нь төслийн үндсэн үйл ажиллагаанаас орох мөнгөн урсгал, үйл ажиллагаанд зарцуулагдан гарах мөнгөн урсгалын зөрүүгээр тодорхойлогдоно.

Мөнгөн урсгалын төрөл	... он	... он
Мөнгөн орлогын дүн	Σ мөнгөн орлого	Σ мөнгөн орлого
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхөөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого		
Мөнгөн зарлагын дүн	Σ мөнгөн зарлага	Σ мөнгөн зарлага
Ажиллагчдад төлсөн		
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		
Бараа материал худалдан авахад төлсөн		
Ашиглалтын зардалд төлсөн		
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн		
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгал	Σ мөнгөн орлого - Σ мөнгөн зарлага	Σ мөнгөн орлого - Σ мөнгөн зарлага

4.2.2 Санхүүжилтийн мөнгөн урсгал нь төсөвлөсөн онд зээл авах, үнэт цаас гаргах замаар орж ирэх санхүүгийн мөнгөн урсгалаас зээл төлөх, ногдол ашиг төлөх гэх мэтээр гарах мөнгөн урсгалыг хасаж тодорхойлно.

4.2.3 Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал нь төсөвлөсөн онд урт хугацаа хөрөнгө борлуулснаас олох мөнгөн орлого болон урт хугацаат хөрөнгө худалдан авахад зарцуулах мөнгөн дүнгийн зөрүүгээр тодорхойлогдоно. Анхны хөрөнгө оруулалтын зардлыг хөрөнгө оруулалтын мөнгөн урсгалын мөнгөн зарлагын дүнд тусгах шаардлагатай.

- 4.2.4 Цэвэр мөнгөн урсгал нь төсөл хэрэгжүүлсний үр дүнд жил тутам хөрөнгө оруулагчдад ногдох мөнгөн урсгал юм. Үйл ажиллагааны мөнгөн урсгал, санхүүжилтийн мөнгөн урсгал, хөрөнгө оруулалтын мөнгөн урсгалын нийлбэрээр тодорхойлогдоно.

Тав. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төслийг үнэлэх

- 5.1 Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төслүүдийг өнөөгийн цэвэр үнэ цэнийн арга, өгөөжийн дотоод хувиар үнэлнэ.

- 5.1.1 Төслийг үнэлэх цэвэр өнөөгийн үнэ цэнийн арга нь төслийн ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ нь анхны хөрөнгө оруулалтаа нөхөөд илүү өгөөжтэй ажиллах боломжийг үнэлнэ. Цэвэр өнөөгийн үнэ цэнийг дараах томъёогоор тооцно.

$$NPV = PV - I_0 = \sum_{t=1}^n \frac{CF_t}{(1+r)^t} - I_0$$

NPV: Өнөөгийн цэвэр үнэ цэнэ

PV: Өнөөгийн үнэ цэнэ

*I*₀: Анхны хөрөнгө оруулалт

CF: Мөнгөн урсгал (Cash flow)

t: хугацааны үе

r: хорогдуулах хувь

- 5.1.2 Төслийн цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах хувийн тусламжтайгаар өнөөгийн үнэ цэнэд шилжүүлнэ. Мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнүүдийн нийлбэрээр өнөөгийн цэвэр үнэ цэнэ гарна. Өнөөгийн цэвэр үнэ цэнэ "0"-ээс их бол төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзнэ.

- 5.1.3 Өгөөжийн дотоод хувь нь эдийн засаг, санхүүгийн эрсдэлээс хамаарч төслийн анхны хөрөнгө оруулалтаа нөхөх хамгийн их хорогдуулах хувийг тооцно. Өгөөжийн дотоод хувийг дараах томъёогоор тооцно.

$$\sum_{t=1}^n \frac{CF_t}{(1+IRR)^t} - I_0 = 0$$

IRR: өгөөжийн дотоод хувь

- 5.1.4 Төслийн цэвэр мөнгөн урсгалууд өнөөгийн үнэ цэнийн нийлбэрийг "0" байлгах хорогдуулах хувийг тооцох ба энэ нь өгөөжийн дотоод хувь болно. Өгөөжийн дотоод хувь нь төслийн хорогдуулах хувиас их бол төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзнэ.

IRR > *r* бол төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой .

IRR < *r* бол төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд өөр санхүүжилтээр хэрэгжүүлэх талаар судлах.

5.2 Төслийн хорогдуулах хувийг капиталын жигнэсэн дундаж зардлын хувийг (WACC) тооцох аргачлалаар тодорхойлно. Төслийн урт хугацаат эх үүсвэр ашиглалтын зардлыг хувиар илэрхийлснийг капиталын жигнэсэн дундаж зардлын хувь гэнэ.

$$WACC = K_e * W_e + K_i * W_i$$

- $WACC$ – Капиталын жигнэсэн дундаж зардлын хувь
 - K_e – өөрийн хөрөнгийн зардлын хувь
 - W_e – нийт урт хугацаат эх үүсвэрт эзлэх өөрийн хөрөнгийн хувийн жин
 - K_i – урт хугацаат зээлийн татварын дараах хүүгийн хувь
 - W_i – нийт урт хугацаат эх үүсвэрт эзлэх урт хугацаат зээлийн хувийн жин
- Энд $W_e + W_i = 100\%$ байна.

5.2.1 Төслийн урт хугацаат зээлийн хүүг татварын дараах байдлаар дараах томъёогоор тооцно.

$$K_i = K_d * (1 - t)$$

K_d - урт хугацаат зээлийн хүүгийн хэмжээ. Төслийг хэрэгжүүлэхийн тулд авах зээлийн хүү бөгөөд жилийн нэрлэсэн дүнгээр тооцно.

t - татварын дундаж хувь хэмжээ. Төслийн үр дүнд төлөх татварын зардлыг татварын өмнөх ашигт харьцуулж тодорхойлно.

5.2.2 Өөрийн хөрөнгийн зардлын хувийг тооцохдоо хөрөнгө үнэ бүрдлийн загвар (CAPM) аргыг ашиглана.

5.2.2.1 Хөрөнгө үнэ бүрдлийн загвар нь эрсдэлгүй хүү дээр эрсдэлийн шагналыг эрсдэлийн түвшнээр тохируулж нэмж тодорхойлдог.

$$k_e = r_f + \beta * (r_m - r_f)$$

r_f - эрсдэлгүй хүү. Засгийн газрын бондын хүүг эсвэл Төв банкны үнэт цаасны хүүг ашиглана.

β - эрсдэлийн түвшин. Төслийг хэрэгжүүлэгч компанийн эрсдэлийг илэрхийлнэ. Компани салбарын дундаж бол 1-тэй тэнцүү. Компани салбарын тэргүүлэгч бол 1-ээс бага, салбарын дунджаас тааруу бол 1-ээс их байна.

r_m - зах зээлийн дундаж өгөөж. Төслийг хэрэгжүүлэгч компанитай ижил салбарын компаниудын эздийн өмчийн дундаж өгөөж.

ҮХГ-ын даргын 2020 оны ... дугаар сарын
... өдрийн ... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Боловсрол, эрүүл мэндийн салбарын төслийн зардал, үр өгөөжийн шинжилгээ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боловсрол, эрүүл мэндийн салбарын төслийн зардал, үр өгөөжийн шинжилгээ нь хязгаарлагдмал хөрөнгө нөөцийн хэмжээнд төслийн үр шимийг хүртэгчдэд хамгийн ихээр нөлөөлөх, хамгийн өндөр үр өгөөж, ач холбогдолтой үр дүн гаргах төслийг тодорхойлоход чиглэнэ.
- 1.2 Боловсрол, эрүүл мэндийн салбарын төсөл нь улс орон, нийгэмд, төслийн үр шимийг хүртэгчдийн сайн сайхан байдалд үзүүлэх нийгмийн үр өгөөж, ач холбогдол өндөртэй байх шаардлагатай гэж үзнэ.

Хоёр. Боловсрол, эрүүл мэндийн салбарын төслийн нийгэм, эдийн засгийн өгөөжийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох

- 2.1 Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын төслийн зардал, үр өгөөжийн шинжилгээг хийхэд ашиглах нийгэм, эдийн засгийн өгөөжийн үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг тооцох. Үүнд:

2.1.1 Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын түвшинд:

1. Нийгмийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлт:

- а) *Хамрагдалтын түвшний өсөлт*: Хамран сургалтын бохир жин боловсролын салбарын хөрөнгө оруулалтын харьцаагаар тооцно. (хамран сургалтын бохир жин/төслийн хөрөнгө оруулалт)
- б) *Нэг мэргэжлийн багшид ногдох хүүхдийн тооны бууралт*: Нэг багшид ногдох хүүхдийн тооны нормоор тооцогдоно. БСШУСЯ-ны сайдын 2003 оны 10-р сарын 01-ний өдрийн 321 дүгээр тушаалын хавсралт, Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх тоон үзүүлэлтүүдийг үндэслэнэ.
- с) *Сургалтын орчин*: Анги, танхим, номын сангийн стандарт хангалтаар хэмжигдэнэ. БСШУСЯ-ны ерөнхий боловсролын сургуулийн эрх зүйн баримт бичиг, сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны MNS6558:2015 стандартыг үндэслэнэ.

2. Эдийн засгийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлт:

- а) *Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бууруулах*: Мэргэжлийн болон мэргэжлийн бус ажлын байрны тооны нэмэгдсэн байдлаар хэмжигдэнэ. Шууд болон шууд бус ажлын байрыг тооцох ба шууд бус ажлын байрыг 1:3 харьцаагаар тооцно.

b) *100,000 хүүхэд тутамд ногдох осол гэмтлийн тоог бууруулах*: Осол, гэмтлээс урьдчилсан сэргийлсэн хүүхдийн тоогоор тодорхойлогдох ба осол гэмтлийн тооны бууралтын мэдээлэлд үндэслэнэ.

2.1.2 Их дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын түвшинд:

1. Нийгмийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлт:

a) *Төвлөрлийг бууруулах*: Цаг, хугацааны мөнгөжүүлсэн дүнгээр тооцогдоно. Уг үзүүлэлт нь 1 цагийн хөдөлмөрийн хөлс, нийт замын түгжрэлд зарцуулсан цаг болон оюутны /багш ажилчдын тоог нэмж болно./ тооны үржвэрээр тооцогдоно. /Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр авч үзвэл 1 цагийн хөлс 2375 төгрөг, судалгаагаар нийслэлд 1 хүн өдөрт дунджаар 2 цаг түгжирдэг, жилд нэг хүн замын түгжрэлд 580 цаг алддаг/

b) *Нэг багшид ногдох оюутны тооны бууралт*: Нэг багшид ногдох оюутны тоогоор тооцогдох ба БСШУСЯ-ны 2007 оны 74-р тушаалын хавсралт, Дээд боловсролын байгууллагад тавих нийтлэг шаардлагад нэмэлт өөрчлөлт оруулах тухай тушаалын 2.2-д тухайн сургуульд багшийн орон тоог мэргэжлийн чиглэлийг тогтоосон харьцаанд үндэслэнэ.

c) *Амьдрах орчны сайжралт*: Дотуур байр, спорт болон ногоон байгууламжийн хангамж, хүрэлцээний нормт хэмжээгээр тодорхойлогдоно. Уг үзүүлэлтийг өмнөх нөхцөл байдлаас сайжирсан эсэхийг тодорхойлох боломжтой. БСШУСЯ-ны 2007 оны 74-р тушаалын хавсралт, Дээд боловсролын байгууллагад тавих нийтлэг шаардлагад нэмэлт өөрчлөлт оруулах тухай тушаалд сургалтын зориулалттай барилга байгууламж нь олон нийтийн иргэний барилга БНбд31-03-03” заасан байр, эрүүл ахуйн норматив, MNS 6541:2015 Мэргэжлийн боловсрол, сургалт, ерөнхий шаардлагад үндэслэнэ.

d) *Суралцах орчны сайжралт*: Анги танхим, лаборатори, номын сангийн хангамж, хүрэлцээний нормт хэмжээгээр тодорхойлогдоно. Уг үзүүлэлтийг өмнөх нөхцөл байдлаас сайжирсан эсэхийг тодорхойлох боломжтой. Мэргэжлийн боловсрол, сургалт, Ерөнхий шаардлага, стандарт MNS6541:2015, дээд боловсролын сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартад үндэслэнэ.

2. Эдийн засгийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлт:

a) *Улс, бүс нутгийн зах зээлд нөлөөлөх нөлөөллийг нэмэгдүүлэх*: Судалгааны ажлын хөрөнгө оруулалтын үр ашгийн үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ. Энэ нь судалгааны ажлыг зах зээлд борлуулсан орлого түүнийг гүйцэтгэхэд

гаргасан зардлын харьцаагаар тооцогдоно. (судалгааны ажлын орлого/зардал)

- b) *Ажил эрхлэлт нэмэгдэх*: Шинээр бий болох ажлын байрны тоогоор хэмжигдэнэ. Шууд болон шууд бус ажлын байраар тооцогдох ба шууд бус ажлын байрыг 1:3 харьцаагаар тооцно.
- c) *Төгсөгчдийн орлогын өсөлт*: Докторын болон төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр, мэргэжлийн зэргийн хөтөлбөрүүдийн тоогоор хэмжигдэнэ. Доктор, магистр, мэргэжлийн зэргийн сургалттай нөхцөлд төгсөгчдийн цалин орлогыг өсгөнө гэж үзээд, төгсөгчдийн цалинг 15 хүртэл хувиар өсгөх боломжтой гэж тооцно.

2.2 Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын төслийн зардал, үр өгөөжийн шинжилгээг хийхэд ашиглах нийгэм, эдийн засгийн өгөөжийн үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг тооцох. Үүнд:

2.2.1 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний түвшинд:

1. Нийгмийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлтүүд:

- a) *Тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх*: Нэг эмчид ногдох хэвтэн эмчлүүлэгчдийн тоо болон нэг эмчид ногдох үзлэгийн тооны үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ. 2017 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор батлагдсан MNS5095:2017 стандартын эмнэлэгийн үйл ажиллагааны онцлогоос хамаарсан орон тооны норм (10 оронд 1 их эмч)-д үндэслэнэ.
- b) *Өвчлөлийн тоог бууруулах нөлөөлөл /халдварт болон халдварт бус өвчлөл/*: Халдварт болон халдварт бус өвчлөлийн өсөлт, эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын өсөлтийн харьцаагаар тодорхойлогдоно. Өвчлөгчдийн түвшингээрх эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын үржүүлэгч буюу халдварт ба халдварт бус өвчлөлийн өсөлтийн хувийг эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын өсөлтийн хувьд харьцуулна. (өвчлөлийн тооны өсөлтийн хувь/ эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын өсөлтийн хувь)

2. Эдийн засгийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлтүүд:

- a) *Эмнэлэгт хэвтэх хүлээлтийн хугацааг бууруулах нөлөөлөл*: 10,000 хүнд ногдох орны тооны өсөлтөөр хэмжигдэхээс гадна нэг эмчид ногдох хэвтэн эмчлүүлэгчдийн тоо, нэг эмчид ногдох амбулаторын үзлэгийн тоо, мөн зайлшгүй хэвтэн эмчлүүлэх шаардлагатай эсэх чанарын үзүүлэлтээр тооцно. 10,000 хүнд ноогдох орны тоог төслийн тусламж үйлчилгээний төрлөөр статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас авч өсөлтийн хувийг тооцно.

- b) *Ажлын байр нэмэгдүүлэх нөлөөлөл*: Шинээр нэмэгдэх ажлын байрны тоогоор хэмжигдэнэ. Шууд болон шууд бус ажлын байраар тооцогдох ба шууд бус ажлын байрыг 1:3 харьцаагаар тооцно.
- c) *Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх*: Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах хүний тооны өсөлтөөр хэмжигдэнэ.

2.2.2 Эм ханган нийлүүлэлтийн түвшинд:

1. Нийгмийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлтүүд:

- a) *Эм, ханган нийлүүлэлтийн хангамжийн эрсдэлийг бууруулах*: Эм ханган нийлүүлэлтийн зайлшгүй байх нөөцийн хэмжээний үзүүлэлтээр хэмжигдэх ба Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон эмийн эзлэх хувийн жинг үндэслэн тооцно.
- b) *Хүн амын эрүүл мэндэд эмийн чанарын үзүүлэх нөлөөлөл*: Чанарын шаардлага хангаагүй эм, эмнэлгийн хэрэгслийн тоо, хэмжээ болон холбогдох стандартын шаардлагыг харгалзан үзнэ. MNS5524-1:2014 эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлагын заалтуудыг бүрэн хангасан байхад үндэслэнэ.
- c) *Импортын эмийн нөлөөлөл*: Эмийн импортын хэмжээгээр хэмжигдэх ба эм зүйн салбарын статистикаас Монгол улсад импортолсон бүтээгдэхүүний нэр төрлийн дэлгэрэнгүй судалгаанд үндэслэн үнэлнэ.

2. Эдийн засгийн үр өгөөжийн шалгуур үзүүлэлтүүд:

- a) *Үнийн хөнгөлөлт*: Үнийн хөнгөлөлтийн хувь хэмжээгээр хэмжигдэнэ. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр, төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ тогтоосон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолд үндэслэнэ.
- b) *Ажлын байр нэмэгдэх нөлөөлөл*: Шинээр нэмэгдэх ажлын байрны тоогоор хэмжигдэнэ. Шууд болон шууд бус ажлын байраар тооцогдох ба шууд бус ажлын байрыг 1:3 харьцаагаар тооцно.
- c) *Төсвийн орлогын нөлөөлөл*: Татварын хэмжээний нэгжийн өсөлтийн төсвийн орлогын өөрчлөлтийн харьцаагаар тодорхойлогдоно. Улсын төсвийн орлогын өөрчлөлтийн хувийг төслийн тооцоогоор татварын хэмжээнд харьцуулах, ҮСХ-ны мэдээлэл, төслийн хүчин чадлын мэдээлэлд үндэслэнэ.

Жишээ:

№	Анхны хөрөнгө оруулалт	Өгөгдөл:	
		Өөрийн санхүүжилтээр	10,000.0 мян.төг
1	Анхны хөрөнгө оруулалт	Урт хугацаат зээлээр	40,000.0 мян.төг
2	Концессын гэрээний хугаа	Бүтээн байгуулалтын хугацаа	2 жил
3	Хөрөнгийн элэгдлийн зардал	Үйл ажиллагаа явагдах хугацаа	8 жил
4	Орлогын албан татварын хувь	200.0 мян.төг	10%
5	Хорогдуулах хувь		13%

Анхны хөрөнгө оруулалт /мян.төг/				
№	Зардлын төрөл	2020	2021	Нийт
1	Үндсэн хөрөнгийн дүн	12,950.0	34,550.0	47,500.0
1.1	Газрын төлбөр	1,000.0	-	1,000.0
1.2	Барилга	10,000.0	30,000.0	40,000.0
1.3	Байгууламж	-	-	-
1.3	Газрын сайжруулалт	1,500.0	-	1,500.0
1.4	Машин, тоног төхөөрөмж	-	1,700.0	1,700.0
1.5	Тээврийн хэрэгсэл	-	900.0	900.0
1.6	Тавилга, эд хогшил	-	1,000.0	1,000.0
1.7	Компьютер, бусад хэрэгсэл	-	300.0	300.0
1.8	Бусад үндсэн хөрөнгө	-	-	-
1.9	Шууд хөрөнгө оруулалттай холбогдон гарах НӨАТ	-	-	-
1.10	Хүүгийн капиталжуулалт	-	-	-
1.11	Бүтээн байгуулалтын үеийн даатгалын зардал	200.0	300.0	500.0
1.12	Хууль, эрх зүйн зардал	100.0	150.0	250.0
1.13	Бэлтгэл ажиллагааны зардал	150.0	200.0	350.0
2	Биет бус хөрөнгийн дүн	1,000.0	0.0	1,000.0
2.1	Зохиогчийн эрх	-	-	-
2.2	Компьютерийн програм хангамж	350.0	-	350.0
2.3	Патент	-	-	-
2.4	Тусгай зөвшөөрөл	650.0	-	650.0

2.4	Ашиглалтын зардалд төлсөн	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	2,000.0
2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	2,400.0
2.6	Хүүний төлбөрт төлсөн	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	2,800.0
2.7	Татварын байгууллагад төлсөн	1,152.0	1,187.0	1,257.0	1,425.0	1,585.0	1,685.0	1,835.0	1,831.0	1,831.0	1,831.0	11,957.0
2.8	Даатгалын төлбөрт төлсөн	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	1,600.0
2.9	Бусад мөнгөн зарлага	1,600.0	1,750.0	1,550.0	1,800.0	1,700.0	1,700.0	1,700.0	1,700.0	1,700.0	1,700.0	13,500.0
3	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	10,568.0	10,883.0	11,513.0	13,025.0	14,465.0	15,365.0	16,715.0	16,679.0	16,679.0	16,679.0	109,213.0

		Хорогдуулалтын хувь тооцох									
№	Үзүүлэлт	Томьёо					Утга				
1	Өөрийн хөрөнгийн хувийн жин	W_e					20%				
2	Урт хугацаат зээлийн хувийн жин	W_i					80%				
3	Төв банкны үнэт цаасны хүү	r_f					11%				
4	Өөрийн хөрөнгийн эрсдлийн шагнал	$(r_m - r_f)$					2%				
5	Бета коэффициент	β					1.0				
6	Өөрийн хөрөнгийн зардлын хувь	$k_e = r_f + \beta * (r_m - r_f) = 11\% + 1 * 2\% = 13\%$									
7	Урт хугацаат зээлийн хүүгийн хувь	K_d					12%				
8	Татварын дундаж хэмжээ	t					10%				
9	Урт хугацаат зээлийн татварын дараах хүүгийн хувь	$K_i = K_d * (1 - t) = 12\% * (1 - 10\%) = 10.8\%$									
10	Капиталын жигнэсэн дундаж зардал /хорогдуулалтын хувь/	$WACC = K_e * W_e + K_i * W_i = 13\% * 20\% + 10.8\% * 80\% = 11.24\%$									

Төр, хувийн хэвшлийн туншлэлээр хэрэгжих төслийг үнэлэх											
№	Үзүүлэлт	Томьёо	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	Дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ /мян.төг/	CF_t	10,568.0	10,883.0	11,513.0	13,025.0	14,465.0	15,365.0	16,715.0	16,679.0	109,213.0
2	Хорогдуулах хувь	$r=11.24\%$	11.24%	11.24%	11.24%	11.24%	11.24%	11.24%	11.24%	11.24%	-
3	Өнөөгийн үнэ цэнийн коэффициент	$1/(1+r)^t$	0.899	0.808	0.726	0.653	0.587	0.528	0.474	0.426	-
4	Өнөөгийн үнэ цэнэ /мян.төг/	$PV = CF_t / (1+r)^t$	9,500.18	8,794.81	8,363.84	8,506.17	8,492.07	8,108.99	7,930.12	7,113.48	66,809.7
5	Анхны хөрөнгө оруулалт /мян.төг/										50,000.0
6	Төслийн цэвэр өнөөгийн үнэ цэнэ /мян.төг/										16,809.7
7	Төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэх	Өнөөгийн цэвэр үнэ цэнэ "0"-ээс их байгаа тул төслийг төр, хувийн хэвшлийн туншлэлээр хэрэгжүүлэх боломжтой. $NPV=16,809.7>0$									
8	Дотоод өгөөжийн хувь /IRR/	$IRR>r$ бол төслийг төр, хувийн хэвшлийн туншлэлээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзнэ.									$IRR=33\%>11.35\%$

ҮХГ-ын даргын 2020 оны ... дугаар сарын
... өдрийн ... дугаар тушаалын гуравдугаар хавсралт

1. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн санал ирүүлэхдээ дараах маягтуудыг бөглөж ирүүлнэ. Үүнд:
 - 1.1 *Маягт 1. Төслийн үндсэн мэдээлэл:* Энэ хэсэгт төслийн нэр, хэрэгжих салбар, байршил, нийт төсөвт өртөг, хэрэгжих хугацаа, төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага зэрэг тухайн төслийн ерөнхий суурь мэдээлэл, судалгааг багтана.
 - 1.2 *Маягт 2. Төслийн нийгмийн ач холбогдол:* Энэ хэсэгт тухайн төсөл хэрэгжсэнээр иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл болон эрүүл, аюулгүй, зохистой орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийн мэдлэг боловсролын түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, тухайн бүс, орон нутгийн хөгжил, байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл болон технологи инновацийн хөгжилд хэрхэн нөлөөлөх зэрэг мэдээлэл багтана.
 - 1.3 *Маягт 3. Төслийн эдийн засгийн үр ашиг:* Энэ хэсэгт экспорт, импортод үзүүлэх нөлөөлөл болон дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тухайн төсөл хэрэгжсэнээр улсад хичнээн төгрөгний татвар, төлбөр хураамж төлөх, шинээр бий болгох ажлын байр зэрэг мэдээллүүд багтана.
 - 1.4 *Маягт 4. Төслийн санхүүжилтийн төлөвлөгөө:* Энэ хэсэгт тухайн төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн хэмжээг санхүүжилтийн эх үүсвэрт эзлэх хувиар тодорхойлсон мэдээлэл багтана.
 - 1.5 *Маягт 5. Төсөл хэрэгжүүлэх Хууль, эрх зүйн орчны болон Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх судалгаа:* Энэ хэсэгт төсөл хэрэгжүүлэхэд нийцэж буй хууль, эрх зүйн акт болон тухайн төслийг хэрэгжүүлэхэд дагалдан боловсруулах, шинэчлэн өөрчлөлт оруулах хууль, дүрэм, журмын талаарх мэдээлэл болон хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилттой нийцэж байгаа байдал, бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдтэй уялдах уялдаа, хамаарал, зөрчилдөж буй хууль тогтоомж байгаа эсэх мэдээллүүд багтана.
 - 1.6 *Маягт 6. Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан байдал:* Энэ хэсэгт шаардлагатай холбогдох суурь судалгаа, шинжилгээ, ТЭЗУС, ТЭЗҮ, бусад Улс орны хувьд ижил төстэй төсөл, арга хэмжээ хэрэгжсэн эсэх талаарх туршлагын судалгаа болон тухайн төсөл хэрэгжих салбар, дэд салбарын холбогдох байгууллагуудаас авсан санал, судалгааны мэдээллүүд багтана.
 - 1.7 *Маягт 7. Төслийн дэд бүтцийн хэрэгцээ:* Энэ хэсэгт хэрэв тухайн төслийг хэрэгжүүлэхэд дэд бүтэц шаардлагатай бол дэд бүтцийн хэрэгцээ шаардлагын талаарх мэдээллийг багтана.

1.8 Маягт 8. Ажлын байр: Энэ хэсэгт төсөл хэрэгжсэнээр бий болох шууд болон шууд бус ажлын байрны тоон мэдээллийг багтаана.

Маягт 1. Төслийн үндсэн мэдээлэл

Төслийн нэр
Төслийн зорилго
Санал ирүүлсэн яам, агентлаг

№	Үзүүлэлт	Танилцуулга		
1	Төсөл хэрэгжих салбар		
2	Төсөл хэрэгжих дэд салбар		
3	Төсөл хэрэгжих байршил /хэд хэдэн байршилд хэрэгжих төсөл бол байршил тус бүрээр мэдээллийг оруулна/	Аймаг, хот 1	
		Сум, дүүрэг 1	
		Хаяг 1	
		Аймаг, хот ... n	
		Сум, дүүрэг ... n	
4	Газрын асуудал шийдэгдсэн эсэх	Үгүй бол	Шалтгаан, тайлбар	
		Тийм бол	Гэрчилгээний дугаар
			Гэрчилгээний төрөл	Аль нэгийг сонгоно уу: а) эзэмших б) ашиглах в) өмчлөх
			Гэрчилгээ олгосон огноо	Он: ... Сар: ... Өдөр:
			Гэрчилгээ дуусах огноо	Он: ... Сар: ... Өдөр: ...
			Шийдвэр гаргасан	Аймаг /нийслэл/: Сум, дүүрэг: Албан тушаал: Нэр:
5	Төслийн нийт төсөвт өртөг: /сая.төгрөгөөр илэрхийлэх ба төслийн нийт төсөвт өртгийн дүн/ сая.төгрөг		
6	Төсөл хэрэгжих хугацаа: /нийт хэдэн жилийн дотор хэрэгжүүлэхээр төлөвлөж байгааг тодорхой бичих/	Бүтээн байгуулалтын үе шат		
		Нийт хугацаа:жил		
		Эхлэх он:		
		Дуусах он:		
		Ашиглалтад орсноос хойш		
		Нийт хугацаа:жил		
		Эхлэх он:		
		Дуусах он:		
7	Төслийн хэрэгцээ шаардлага	Эрэлт, хэрэгцээ, шаардлага	
		Зах зээлийн өнөөгийн төлөв байдал	
		Хүрээлэн буй орчинд ээлтэй технологи, менежментийн шийдэлтэй эсэх:		

8	Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө	<p>.....</p> <p>.....</p> <p>Хүрээлэн буй орчныг хамгаалах хариуцлагын тогтолцоог нэвтрүүлсэн эсэх:</p> <p>.....</p> <p>.....</p>										
9	Бүс, орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө	<p>Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн эдийн засгийн хэрэгцээ, шаардлагыг хангаж буй эсэх:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангаж буй эсэх:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн дэд бүтцийн хэрэгцээ шаардлагаг хангаж буй эсэх:</p> <p>.....</p> <p>.....</p>										
10	Хувийн хэвшил өөрийн санаачлалаар төслийн санал ирүүлсэн бол	<table border="1"> <tr> <td data-bbox="603 824 1082 869">Байгууллагын нэр:</td> <td data-bbox="1082 824 1402 869">.....</td> </tr> <tr> <td data-bbox="603 869 1082 913">Үйл ажиллагааны чиглэл:</td> <td data-bbox="1082 869 1402 913">.....</td> </tr> <tr> <td data-bbox="603 913 1082 958">Үүсгэн байгуулагдсан огноо:</td> <td data-bbox="1082 913 1402 958">.....</td> </tr> <tr> <td data-bbox="603 958 1082 1025">Туршлага, гүйцэтгэж байсан томоохон ажлын мэдээлэл:</td> <td data-bbox="1082 958 1402 1025">.....</td> </tr> <tr> <td data-bbox="603 1025 1082 1070">Байгууллагын санхүүгийн чадаахи:</td> <td data-bbox="1082 1025 1402 1070">.....</td> </tr> </table>	Байгууллагын нэр:	Үйл ажиллагааны чиглэл:	Үүсгэн байгуулагдсан огноо:	Туршлага, гүйцэтгэж байсан томоохон ажлын мэдээлэл:	Байгууллагын санхүүгийн чадаахи:
Байгууллагын нэр:											
Үйл ажиллагааны чиглэл:											
Үүсгэн байгуулагдсан огноо:											
Туршлага, гүйцэтгэж байсан томоохон ажлын мэдээлэл:											
Байгууллагын санхүүгийн чадаахи:											
11	Байгуулсан гэрээ, хэлэлцээр: /Санхүүжилтийн, бүтээгдэхүүн борлуулалтын, тоног төхөөрөмж эсвэл түүхий эд материал нийлүүлэх, зөвлөх үйлчилгээний г.м ямар нэг хамтарч ажиллах гэрээ, хэлэлцээр төслийн хүрээнд байгуулагдсан эсэх талаарх мэдээлэл/	<p>а) Гэрээний төрөл: /санхүүжилтийн, зөвлөх үйлчилгээний, барилга угсралтын, тоног төхөөрөмж нийлүүлэлтийн г.м/</p> <p>б) Гэрээлэгч байгууллагын нэр:</p> <p>Гэрээ хийгдсэн огноо:</p> <p>Гэрээлэгч байгууллагын танилцуулга:</p>										
12	Төслийн өнөөгийн байдал: /төслийн хүрээнд хийгдсэн ажлуудын талаар товч танилцуулга/	<p>.....</p> <p>.....</p>										
13	Бүтээгдэхүүн, үйлчилгээний товч танилцуулга	<p>.....</p> <p>.....</p>										
14	Яам, агентлагаас тухайн төслийг хариуцсан мэргэжилтэн	<p>Нэр:</p> <p>Албан тушаал:</p> <p>Утас /ажил, гар/:</p> <p>И-мэйл:</p>										
15	Хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч байгууллагаас тухайн төслийг хариуцсан ажилтан	<p>Нэр:</p> <p>Албан тушаал:</p> <p>Утас /ажил, гар/:</p> <p>И-мэйл:</p>										

Маягт 2. Төслийн нийгмийн ач холбогдол

№	Үзүүлэлт	Танилцуулга
1	Нийгмийн/иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл	
2	Иргэдийн эрүүл, аюулгүй, зохистой орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд нөлөөлөх нөлөөлөл	
3	Иргэдийн мэдлэг, боловсролын түвшинг дээшлүүлэхэд үзүүлэх нөлөөлөл	
4	Ядуурлыг бууруулахад нөлөөлөх нөлөөлөл	
5	Тухайн бус, орон нутгийн хөгжилд үзүүлж буй нөлөөлөл	
6	Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл	
7	Технологи, инновацийн хөгжилд нөлөөлөх нөлөөлөл /Нэвтрүүлэх дэвшилтэт техник, технологи тус бүрээр/	
8	Бусад	

Маягт 3. Төслийн эдийн засгийн үр ашиг

№	Үзүүлэлт	Танилцуулга
1	Экпортод чиглэсэн	
2	Импортыг орлох	
3	Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	
4	Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих	
5	Төсөл хэрэгжих хугацаанд улсад төлөх нийт татвар, төлбөр хураамж /сая.төг/	
6	Шинээр бий болгох ажлын байрны тоо	
7	Бусад	

Маягт 4. Төслийн санхүүжилтийн төлөвлөгөө

№	Төлөвлөж буй санхүүжилтийн эх үүсвэр	Нийт санхүүжилтэд эзлэх хувь
1	Төсөл санаачлагч өөрийн санхүүжилтээр	
2	Гадаадын хөрөнгө оруулалтаар	
3	Дотоодын хөрөнгө оруулалтаар	
4	Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлээр	
5	Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлээр	

Маягт 5. Төсөл хэрэгжүүлэх Хууль эрх зүйн орчны болон Улс, бүс нутаг, орон нутаг, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх судалгааны маягт

№	Үзүүлэлт	Төслийн танилцуулга
Төсөл хэрэгжүүлэхэд холбогдох хууль эрх зүйн орчин, үндэслэл		
1	Төсөл хэрэгжүүлэхэд холбогдох Хууль эрх зүйн акт /хууль эрх зүйн актуудын нэр, холбогдох заалтууд/	
2	Төслийг хэрэгжүүлэхэд дагалдан боловсруулах, шинэчлэн өөрчлөлт оруулах хууль, дүрэм, журам байгаа эсэх /Хэрэв байгаа бол ямар хууль, дүрэм,	

	журам боловсруулах, шинэчлэн өөрчлөлт оруулах шаардлагатай байгааг судалгаа, үндэслэл, шалтгааны хамт тодорхой бичих/	
3	Төрийн дэмжлэг, онцгой зохицуулалт /аливаа хууль, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу онцгой зохицуулалтад хамрагдах эсэх эсвэл татварын болон татварын бус хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, экспорт, импортын хязгаарлалт, урамшуулал эдлэх г.м төрийн дэмжлэгийн хэлбэрүүд/	
Хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилттой нийцэж байгаа эсэх		
1	Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцэх байдал /Дэлхийн тогтвортой хөгжлийн 17 чиглэлийн, 169 зорилтоос яг аль зорилтыг хангахад нөлөөлөхийг тодорхой бичнэ/	
2	Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого 2020-2050-тай нийцэх байдал / аль зорилтыг хангахад нөлөөлөхийг тодорхой бичнэ./	
3	10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал / аль зорилтыг хангахад нөлөөлөхийг тодорхой бичнэ./	
4	5 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал / аль зорилтыг хангахад нөлөөлөхийг тодорхой бичнэ./	
5	"Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-тэй нийцэж буй байдал /хэддүгээр заалттай хэрхэн нийцэж буйг тодорхой бичнэ/	
6	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж буй байдал /хэддүгээр заалттай нийцэж буйг тодорхой бичнэ/	
7	Төсөл хэрэгжих салбарын төрөөс баримтлах бодлогод нийцэж буй байдал /Бодлогын баримт бичгийн нэр, заалтыг тодорхой бичнэ/	
8	Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал	
9	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцэж буй байдал /Бодлогын баримт бичгийн нэр, заалтыг тодорхой бичнэ/	
10	Үндэсний хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичигтэй нийцэж буй байдал /Бусад ямар ямар бодлогын бичиг баримттай хэрхэн нийцэж буйг тодорхой бичнэ/	
Бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдтэй уялдах уялдаа, хамаарал		
1	УХОХ-т туссан төсөл, арга хэмжээтэй уялдах байдал	
2	Тухайн бүс, орон нутагт хэрэгжиж буй бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдтэй уялдах байдал	

3	Тухайн салбарт хэрэгжиж буй бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдтэй уялдах байдал	
4	Үндэсний хэмжээнд хэрэгжиж буй бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдтэй уялдах байдал	
5	Уялдан хэрэгжих ямар нэг төсөл, хөтөлбөр, арга хэмжээ байхгүй бол энэ тухай тодорхой тайлбарлах /үндэслэл, шалтгаан г.м/	
Зөрчилдөж буй хууль тогтоомж байгаа эсэх		
1	Тухайн төслийг зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага бий боловч зарим хууль тогтоомж, журамтай зөрчилдөж байгаа эсэх /Хэрэв тийм бол ямар хууль тогтоомжтой зөрчилдөж байгааг үндэслэл, шалтгааны хамт тодорхой бичнэ үү./	

Маягт 6. Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан байдал

№	Судалгаа шинжилгээний ажил, боловсруулсан баримт бичгийн бүрдэл	Хийгдсэн эсэх	Танилцуулга
1	Суурь судалгаа: /Хууль эрх зүйн орчин, төслийн эрэлт, хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлын шинжилгээ г.м суурь судалгаануудыг тусгах/	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар: Хийгдсэн бол: Гүйцэтгэсэн байгууллагын нэр: Хийгдсэн огноо: Нэмэлт өөрчлөлт хийсэн бол сүүлийн өөрчлөлтийн огноо: Хийгдсэн судалгааг ирүүлэх.
2	Макро эдийн засгийн өнөөгийн байдлын шинжилгээ /ДНБ, эдийн засгийн өсөлт, төсөл хэрэгжих салбарын ДНБ-д эзлэх хувь, г.м макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд шинжилгээ хийж, төсөлд/төслийн үзүүлэх нөлөөллийг урьдчилсан байдлаар томъёолно./	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар: Хийгдсэн бол: Хийгдсэн судалгаа, шинжилгээний үр дүнг ирүүлэх.
3	Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын өнөөгийн байдлын шинжилгээ /төсөл хэрэгжих салбар, дэд салбарын хөгжлийн түвшин, үр дүн, нөхцөл байдлыг тодорхойлдог үндсэн суурь үзүүлэлтүүд ямар байгаа, тэдгээрийг урт, дунд, богино хугацаандаа хэрхэн өөрчлөх зорилтыг засгийн газраас дэвшүүлсэн болох, тэдгээр	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар: Хийгдсэн бол: Хийгдсэн судалгаа, шинжилгээний үр дүнг ирүүлэх.

	зорилтоо хангах үүднээс авч хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүд, тэдгээрийн явц, үр дүн ямар байгаа зэргийг тодорхойлно./		
4	ТЭЗУС:	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар:
		Хийгдсэн бол:	Судалгаа хийгдсэн огноо: Хийгдсэн судалгааг ирүүлэх.
5	ТЭЗҮ	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар:
		Хийгдсэн бол:	Судалгаа хийгдсэн огноо: Хийгдсэн судалгааг ирүүлэх.
6	Бусад Улсын хувьд ижил төстэй төслийн хэрэгжсэн байдлын талаарх туршлагын судалгаа:	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар:
		Хийгдсэн бол:	Судалгаа хийгдсэн огноо: Хийгдсэн судалгааг ирүүлэх.
7	Бодлогын судалгаа:	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар:
		Хийгдсэн бол:	Судалгаа хийгдсэн огноо: Хийгдсэн судалгааг ирүүлэх
8	Зураг, төсөв:	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар:
		Хийгдсэн бол:	Гүйцэтгэсэн байгууллагын нэр: Хийгдсэн огноо: Нэмэлт өөрчлөлт хийсэн бол сүүлийн өөрчлөлтийн огноо: Хийгдсэн судалгааг ирүүлэх.
9	Тухайн төсөл хэрэгжих салбар болон дэд салбар зэрэгт холбогдох байгууллагуудаас санал, судалгаа авсан эсэх	Аваагүй бол шалтгаан тайлбар:
		Авсан бол:	Санал өгсөн болон дэмжсэн тухай албан тоот бичиг, нотлох баримтыг ирүүлэх.

Шууд ажлын байр: Тухайн төслийг хэрэгжүүлснээр бий болгосон шууд хөдөлмөр эрхлэлт буюу шууд цалинждаг, хөдөлмөрийн гэрээ хийсэн үндсэн ажилтнууд ба төслийн талбай дээр байнга ажиллах гэрээт ажилтнууд орно.

Шууд бус ажлын байр: Тухайн төслийг хэрэгжүүлснээр бий болгосон шууд бус хөдөлмөр эрхлэлт буюу гэрээлэгчид, тухайн компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажил хийдэг хүн орно. Энэ нь урт хугацааны ажлын байр биш байж болно. Жишээ нь: Гэрээт байгууллагаас цалинждаг, төслийн ханган нийлүүлэгч байгууллага эсхүл гэрээт байгууллагын ханган нийлүүлэгч ба гэрээлэгч байгууллагад ажилладаг.

T1	Төслийн бэлтгэл ажил хийгдэж байх хугацааны үед
	Төслийн бүтээн байгуулалт хийгдэж байх хугацааны үед
T2	Бүтээн байгуулалт дуусаж, ажиллуулах туршилтын хугацааны үед
	Туршилтын хугацааны дараа буюу үйл ажиллагаа жигдэрснээс хойших үед